



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 1192

Шивээговь сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 27 дугаар зүйлийн 27¹.3, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1, 15.5.2, 16 дугаар зүйлийн 16.1.3, 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2 дугаар багийн нутаг Хөтөл 5-3 тоотод байрлах иргэн Буманцэцэгийн Батбаяр, Хөтөл 6-2 тоотод байрлах малчин Ухнаадоржийн Түмэндэмбэрэлийн суурьт бог малын гоц халдвар мялзан өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн тул 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Гоц халдварт мялзан өвчний хязгаарлалтын дэглэм цуцлах хүртэл хугацаанд хязгаарлалтын бүс нутагт хүн болон техник хэрэгсэл, малын шилжилт хөдөлгөөн хийхийг бүрэн хориглосугай.

3.Хязгаарлалтын бүсийг тогтоож, малчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, заавар зөвлөгөө өгөх, тандалт үзлэг хийх, хязгаарлалтын бүсэд байгаа малд үзлэг, ариутгал халдваргүйтгэл хийхийг “Хийморь Алтай групп” ХХК-ийн захирал (А.Цэрэндолгор)-т, хорио цээрийн бүс рүү хүн, мал, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхгүй байхад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга (Б.Шинэбаяр)-т, малчин өрхийн отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөний нөхцөл байдалд тандалт хийж, зөвшөөрөлгүй отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийлгэхгүй байх, гадны аймаг сумдаас отор нүүдлээр ирүүлэхгүй байх, хээлтүүлэгч мал, хурдан морь, бусад мал амьтныг

худалдаж авахгүй байхыг анхааруулж, малчид, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэхийг Нэрт, Бэхт багийн Засаг дарга нарт, ажлын гүйцэтгэл, явцыг тухай бүр баримтжуулж, дээд шатны байгууллагад тогтмол дамжуулж мэдээллэхийг Онцгой комиссын гишүүн (П.Ганжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга (Ч.Сугармаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ

